Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

# Анхдугаар ТАВАН ЖИЛ

Төв аймгийн намын хороо, А.Д.Х.Гүйцэтгэх захиргааны сонин.

17 дэх жилдээ №45 (1380) | 1964 оны 6 дугаар сарын 8 | ДАВАА

# Нэгдлийн ардчиллыг тууштай биелүүлье

Хөдөлмөрч малчдын сайн дураараа хүч хөрөнгөө нэгтгэж байгуулсан хамт олны аж ахуй нэгдэл нь нэгдэлч олны хүсэл эрмэлзлэлийг тусгаж дотоод дүрэм баталж үйлдвэрлэлийн ажлыг удирдуулахаар нэгдлийн ерөнхий хороог сонгон ажиллуулдаг билээ.

Нэгдлийн ерөнхий хороо нь өөрийн ажлыг ерөнхий хорооны гишүүдийн оролцоотойгоор хөтлөж мал аж ахуй, газар тариалан аж ахуйн бусад туслах салбаруудыг хөгжүүлэх, улирал, жилийн ба хэтийн төлөвлөгөөг боловсруулан түүнийгээ нэгдлийн гишүүдээр хэлэлцүүлж тэдний санал хүсэлтийг үндэс болгож зохион байгуулан удирдах ёстой.

Гэтэл манай зарим нэгдэлд ардчиллыг тууштай хэрэгжүүлэн биелүүлэх талаар анхаарахгүй, гишүүд олноор шийдвэрлэвэл зохих асуудлыг ганц дарга өөрийн үзэмжээр шийдвэрлэх буюу нэгдлийн гишүүд, нэгдлийн ажлыг хянах, санал зөвлөлгөөн өгөх чухал хэлбэр болсон нэгдлийн бүх гишүүд төлөөлөгчдийн хурлыг таслах, нэгдлийн дарга нарыг халж өөрчлөхөд тайланг тавиулахгүй явуулах, нэгдлийн өмнө аж ахуй, соёл гэгээрлийн талаар тавигдаж байгаа үүрэг зорилтуудыг нэгдэл бригадын хурал зөвлөлгөөнөөр хэлэлцүүлэхгүй байх зэргээр нэгдлийн гишүүн олны эрх хэмжээг үл тоомсорлох ноцтой дутагдал, Эрдэнэсант, Баянжаргалан, Баянбараат сум—нэгдлийн ерөнхий хороодын ажиллагаанд гарч байв.

Нэгдлийн ерөнхий хороо нь гишүүдийг зөвхөн үйлдвэрлэлд зохион байгуулах төдийгүй бас нэгдлийн гишүүдийг социалист аж ахуйн зарчим болон үзэл суртлын талаар сурган хүмүүжүүлэх төв аппарат мөн.

Иймээс нэгдлийн ерөнхий хорооны зохион явуулж байгаа удирдамж нь ерөнхий хорооны гишүүдийн буюу төлөөлөгчдийн хурлын шийдвэр байх ёстой.

Нэгдлийн дүрэмд бүх гишүүдийн хурлыг жилд нэг удаа, төлөөлөгчдийн хурлыг улирал бүрт, ерөнхий хорооны гишүүдийн хурлыг сард 1-2 удаа хийж ээлжит асуудалд ялангуяа төсөв хөрөнгийн зарцуулалт, бригадын суурийн ахлагчдын илтгэлийг сонсох, мал үржил, тэжээл бэлтгэх, билчээр ашиглах, үйлдвэр санхүүгийн төлөвлөгөө ба даалгаврын биелэлтийг сонсож тодорхой заалт гарган энэ хурлуудад нэгдлийн тэргүүний гишүүдийг аль болох олноор оролцуулан тэдний санал шүүмжлэлийг өрнүүлж байх ёстой. Иймд учраас нэгдлийн бүх шатны хурлууд нь нэгдлийн ажилд тэдний идэвх санаачлагыг гаргуулах, тэдний санал хүсэлтийг авах, тэднийг хамтын үйлдвэрлэлд хүмүүжүүлэх чухал хэлбэр мөн. Нэгдлийн ардчиллын хуралд төвлөн удирдах ёсыг үгүйсгэхгүй юм. Энэ нь нэгдэл бригадын дарга нар үйлдвэрлэлийн төлөвлөгөөний явцыг шаардах, бригад, суурь дээр хяналт шалгалтыг зохион байгуулах, гишүүдийг хөдөлмөрт хувиарлах ба ажлыг авах, үнэлэх зэргийг зоригтой санаачлагатай хийж байхыг шаардана. Нэгдлийн ардчиллыг хөгжүүлэхэд түүний үйлдвэрлэлийн биеэ даасан нэгж болох бригад их роль гүйцэтгэнэ.

Бригадын гишүүдийн хурлаар сонгогдсон бригадын зөвлөл нь нэгдлийн гишүүдийг өдөр дутам нэгдлийн үйлдвэрлэлд ажиллуулах хэсэг суурь, фермийн үйлдвэрлэлийн даалгаврын биелэлтийг хянаж удирдахын хамт нэгдлийн ажил хэрэгт гишүүдийн санал эрмэлзлэлийг гаргуулах, ажлын ололт дутагдлыг илрүүлж, санал туршлагыг авч байхаар бригадын хурлыг сар бүрийн эцэст тогтмол хийж байх ёстой.

Гэтэл бригадын хурлыг тогтмол хийхгүй аж ахуй, соёл хүмүүжлийн асуудлыг гишүүдээр хэлэлцүүлдэггүй практик их байна. Нэгдлийн ардчиллыг түүний дүрмийн дагуу ягштал биелүүлэхэд намын байгууллагууд хяналт ба санаачлагыг байнга гаргаж байх ёстой. Нэгдлийн ардчиллыг биелүүлэхэд шалган байцаах комисс эдгээр ажлуудын гадуур өнгөрөх ёсгүй. Одоо нэгдлийн ерөнхий хороо энэ оны эхний хагас жилд хийж гүйцэт гэсэн ажлын тайланг төлөөлөгчдийн хурлаар 7 дугаар сарын эхэнд багтааж хэлэлцүүлэх хэрэгтэй.

Нэгдлийн ерөнхий хороо, түүний гишүүн бүр нэгдлийн 1964 оны үйлдвэрлэлийн программыг хангаж биелүүлэх талаар идэвхтэй тэмцэл тавьж үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөг үзүүлэлт нэг бүр дээр хангах хэрэгт бригад, суурь, гишүүн бүртэй тодорхой ажиллах нь чухал байна.

Нам, залуучуудын эвлэл, эмэгтэйчүүдийн зэрэг олон нийтийн байгууллагууд нэгдлийн ардчиллыг элдэв шалтгаанаар зөрчин гажуудуулах явдалтай хатуу тэмцэж нэгдлийн ажилд гишүүд олны зүгээс тавих хяналтыг үргэлж сайжруулж байх нь чухал байна.

## Худалдаа бэлтгэлийг удирдах газрын дарга Гончигт

**Танай аймгийн хөдөлмөрчид ноолуур, мал бэлтгэх төлөвлөгөөг биелүүлсэнд талархаж төлөвлөгөөт бусад зорилтоо биелүүлэх тэмцэлдээ өндөр амжилт гаргахыг хүсье.**

*БНМАУ—ын Худалдаа бэлтгэлийн яамны сайдыг Ц.Намсрай*

## Хаврын тариалалт дуусав

Жаргалантын сангийн аж ахуй энэ онд улсын төлөвлөгөөгөөр 30880 га газар үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн ургамал тариалах юм. Үүний дотроос 2950 га талбайд үр тариа тариалах асар их ажил САА-н үр тарианы 4 тасаг, 11 бригадад амжилттай явагдаж урьдчилсан дүнгээр үр тарианы нэр төрлийн төлөвлөгөөг 100—111 хувийн биелэлттэйгээр ажлын 18—20 хоногт үндсэндээ дуусав.

Хаврын тариалангийн ажлын үед Моломжамц даргатай Загдал тасгийн хамт олон техник ашиглалт, хөдөлмөр зохион байгуулалтыг сайн хийснээр 6838 га-д хаврын агерагт хагалгаа явуулан, 11564 га талбайд үр суулгаж улсын төлөвлөгөөг биелүүлэн бусад тасгаас түрүүлэн амжилт гаргасан учир САА-н захиргаа, ҮЭ-ийн нэгдсэн хорооны социалист уралдаанд шилжин явах туг, мөнгөн шагнал удаа дараа хүлээн авчээ. Мөн Чойндондорж даргатай Батсүмбэр тасаг, 4775 га—д хаврын хагалгаа явуулан 7275 га-д үр тариа суулгаж дараах байранд орсон байна. Тус сангийн аж ахуй ийм дүнтэйгээр 1964 оны хаврын тариалангийн ажил үндсэндээ төгсөж одоо ногооны 6,8 малын тэжээлийн 14 дүгээр бригадууд төмс хүнсний ногоо, эрдэнэ шиш вандуй, ногоон тэжээл зэрэг малын тэжээлийн ургамалууд тариалах үргэлжлэн амжилттай явагдаж ойрын хугацаанд дуусгахаар ажиллаж байна. Жаргалантын сангийн аж ахуйн нам, захиргааны байгууллагууд түүний хамт олон хаврын тариалалтын ажлаа дуусгаад санаа амарч, сэтгэл тайвширахгүй улмаар 15000 га-д зуны пар хагалах, тариа ногооны олон зуун га-д арчилалт, тордолт, услалт, мөр хоорондын боловсруулалт явуулахын хамт өвс хадлан ба намрын тариа ногоо хураалтын аж ахуй, зохион байгуулалтын бүх бэлтгэлийг хангаж ялангуяа техник засварлалтын ажлыг амжилттай эхэлж, нарийн зохион байгуулалттай явуулах том зорилтууд тулгарч байгааг анхааран улам шургуу ажиллах явдал шаардагдаж байна

*Т.Ванзравч*

## Сурагчийн ирүүлсэн шуурхай мэдээ

### Эмэгтэйчүүд их хурлынхаа өмнө

Жаргалантын сангийн аж ахуйн Пүрэвээ даргатай цэцэрлэгийн асрагч, хүмүүжүүлэгчид Монголын эмэгтэйчүүдийн их хурлыг угтаж сум—сангийн аж ахуйн эмэгтэйчүүдэд уриалга гарган тодорхой үүрэг аваад ажиллаж байна.

Тэд их хурлын нэрэмжит цэцэрлэг байгуулж, 25 ширхэг орны хэрэглэл оёхоос гадна асрагч Доржгочоо, Цэвэлмаа, угаагч Чанцал, хүмүүжүүлэгч Дунжмаа. Цэвээнсүрэн, тогооч Санж нар авсан үүргээ амжилттай биелүүлэхээр мэрийлттэй ажиллаж байна.

### Их хадлангийн ирмүүн бэлтгэл

Жаргалантын сангийн аж ахуй 1964 оныхоо тариалалтын ажлыг амжилттай дуусгаж, хадлангийн бэлтгэл ажилд эртнээс шамдан орлоо.

Тус сангийн аж ахуйнхан 3500 тонн хадлан авахын тулд 6 дугаар сарын 15—ны дотор хадлангийн бэлтгэл ажлыг дуусгаж арвин их өвс тэжээл бэлтгэхээр бэлтгэл ажлаа шуурхай хийж байна.

### 4000 төгрөг

Жаргалантын 11 жилийн дунд сургуулийн 7, 8 дугаар ангийн сурагчид аж ахуйн хаврын тариалалтын, бордоо тараалалтын ажилд тусалж 4000 шахам төгрөгийн ашигтай ажил хийв.

Энэ ажилд нийт сурагчид идэвхтэй оролцсоны дотроос 8 дугаар ангийн сурагч Мандаа, Жамъянсамбуу, Нормоожав, Бат—Очир, 7 дугаар ангийн сурагч Лувсандорж, Цэдэвсүрэн нар онц идэвхтэй ажиллав.

### Шалгалтын танхимаас

Жаргалантын 11 жилийн дунд сургуулийн багш Базарын удирдсан 10 дугаар ангийн сурагчид, багш Сэсэнжавын удирдсан 8—ын „Б" ангиуд анги дэвших ба улсын шалгалтанд 100 хувийн сурлагын амжилт үзүүллээ.

10 дугаар ангийн сурагч Тогоонтөмөр, Санжаа. 8 дугаар ангийн сурагч Дашцэрэн, Алтангэрэл, Доржханд, Нормоожав нар онц дүнтэй шалгагдав.

*Ш.Бадарч*

## Байгалийн ширүүн авиртай шуурхай тэмцэж байна

Тус аймгийн нийт нутгаар 6 дугаар сарын 7-ний өдрөөс эхлэн бороо орж 8-ны өдрийн 12 цагаас цас унаж эхлэв. Лүн, Эрдэнэсант, Өндөрширээт Жаргалант, Заамар сумдын нутгаар цас 30—40 см унаж бүрэн биш мэдээгээр 2000 гаруй мал үхээд байна.

Аймгийн намын хороо, АДХ-ын Гүйцэтгэх захиргаа байгалийн ширүүн байдалтай байгаа сумдад бие төлөөлөгч гаргав. Малчдад туслах хүн хүч, унаа хөсөг, эсгий биржент, халх, майхан зэрэг зүйлийг аймаг, сумын төвөөс суурь бригадад хүргэж малчдын ажилд биечлэн тусалж малын үхэл зогсоох арга хэмжээ авч байгалийн ширүүн авиртай шуурхай тэмцэж байна.

# Бага хурлынхаа шийдвэрийг шуурхай биелүүлье

Монгол—Зөвлөлтийн найрамдалын нийгэмлэгийн аймгийн зөвлөлийн 6 дугаар бага хурал саяхан болж ажлаа дүгнэв.

МЗНН—ийн аймгийн зөвлөл, Зөвлөлт Холбоот Улсын үйлдвэр, хөдөө аж ахуй, соёл шинжлэх ухаан, техникийн хөгжил, гардан бүтээгч Зөвлөлтийн баатарлаг ард түмний коммунист ёсоор ажиллаж, сурч, амьдарч байгаа туршлагыг өргөнөөр сурталчлан тайлбарлаж түүнийг өөрсдийн ажил амьдралд хэрэгжүүлэн нэвтрүүлэх, Монгол—Зөвлөлтийн ард түмний найрамдлыг улам бэхжүүлэх, нийгэмлэгийнхээ эгнээг өргөтгөхөд ажлаа чиглүүлэн зохиож иржээ.

Тус зөвлөл 5 дугаар бага хурлын үед 6017 гишүүнтэй байсан бол одоо 6753 гишүүнтэй болж эгнээ нь 12,2 хувиар өсчээ.

Тайлангийн хугацаанд аймгийн зөвлөл Монгол—Зөвлөлтийн най рамдлын уламжлалт сарын ажлыг тэмдэглэн өнгөрүүлэх, Зөвлөлт Холбоот Улсын баатарлаг ард түмний бахдам амжилтыг сурталчлах, тэдний туршлагыг ний тийн хүртээл болгох зорилгоор үдэшлэг уулзалт зохиох, лекц яриа хийх, үзэсгэлэн самбар байгуулах, радио нэвтрүүлэг явуулах олон хэлбэрийн ажил явуулж төв хөдөөд нийт 119679 хүнд сурталчилсан байна.

Зөвлөлтийн ард түмний ажил амьдрал, хувьсгалт тэмцэл харуулсан киноны 7,10 хоногуудыг нийт сум, сангийн аж ахуй, аймгийн төвд бэлтгэл сайтай зохиосон байна.

Тус аймагт ажиллаж байгаа Зөвлөлтийн мэргэжилтнүүдтэй 59 удаа уулзалт хийж, Зөвлөлтийн ард түмний коммунизм байгуулж байгаа арга туршлага, Зөвлөлтийн хамтралуудын ажил, хүмүүсийн соёл, дадал заншлыг сурталчилсан нь Зөвлөлтийн ард түмний ажил амьдралаас сурах, түүнийг манай хөдөлмөрчид малчдаас ажил амьдралдаа хэрэглэх яв далд нилээд тус дөхөм болсон байна. Эрдэнэ, Архуст, Өндөрширээт, Их хайрхан, Сэрэглэн, Алтанбулаг, аймгийн төвийн 10 жил, төвийн артелийн дэргэдэх салбар зөвлөлүүд хөдөлмөрчдийн дунд зохиох үзэл суртал, зохион байгуулалтын ажлаа сайжруулан Зөвлөлтийн ард түмний баялаг туршлагаас сурах талаар сайн ажиллажээ.

Одоо аймгийн хэмжээгээр 111 хүн Зөвлөлтийн мэргэжилтнийг дагалдан сурч байгаагийн дотор Баянчандмань, Батсүмбэр, Их хайрханы уурхайн дэрэгдэх МЗНН—ийн байгууллагууд нам, олон нийтийн байгууллага сайн зохион байгуулжээ.

Гэвч, МАХН—аас дэвшүүлэн тавьсан зорилт, орчин үеийн манай орны хөгжлийн шаардлага, нийгэмлэгийн гишүүд, нийт хөдөлмөрчдийн хэрэгцээт шаардлагаас тус аймгийн МЗНН—ийн байгууллагуудын ажил зарим талаар хоцорч, нийгэмлэгийн ажил жигд сайжраагүй байна.

Ялангуяа үндсэн салбар зөвлөлүүдийн ажил тун ч хангалтгүй байгаа нь МЗНН—ийн нийт ажлыг сулруулах муу нөлөө болжээ. МЗНН—ийн зөвлөл, салбаруудаас зохиож байгаа гэгээрэл, олон түмний ажил тогтмол биш, Зөвлөлтийн ард түмний баялаг туршлагыг бүтээлчээр нэвтрүүлэх, хүн бүрт эзэмшүүлэх, түүний арга барилыг зааж сургах ажлыг хангалтгүй хийж иржээ. МЗНН—ийн үндсэн салбар зөвлөлүүдийн дотор тэргүүлэгчдийн ба бүх гишүүдийн хурал, улирал, сарын ажлын төлөвлөгөө нь тогтмолжоогүй, тайлан мэдээг зохих хугацаанд нь үнэн зөв гаргахгүй зэрэг дутагдал оршиж байжээ. Бүрэн, Эрдэнэ, Эрдэнэсант сумын зөвлөлүүдийн хэмжээгээр тайлангийн хугацаанд гишүүд нь 25—34 гишүүнээр буурсан, Баянбараат сумын зөвлөл ажлын төлөвлөгөөгүй, гишүүдийн тоо бүртгэлгүй зэрэг дутагдал оршиж байгааг тус бага хурлын төлөөлөгчид хурц шүүмжлэн илрүүлэв.

Эдгээр дутагдлын үндсэн шалтгаан нь аймгийн зөвлөл, үндсэн зөвлөл, салбаруудынхаа ажлыг тодорхой удирдлагаар хангаагүй, зөвлөлийн ажиллагаа хөнгөн шуурхай биш, доод байгууллагуудаа тавих зарчимт өндөр шаардлага, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг сулруулснаас болжээ гэж бага хурал дүгнэв.

МЗНН—ийн гол ажил бол коммунизм байгуулж байгаа ЗХУ—ын баатарлаг ард түмний түүхэн туршлагууд, Монгол—Зөвлөлтийн ард түмний уламжлалт найрамдал, Зөвлөлтийн ард түмнээс манай эх орны хөгжилт цэцэглэлтэд үзүүлж байгаа сэтгэл харамгүй өгөөмөр тусламжийг нийт хөдөлмөрчдөд тайлбарлан таниулах ажлыг өргөн зохиож, нийгэмлэгийн байгууллагуудаас зохиох гэгээрэл олон түмний ажлын хүрээг өргөтгөн арга хэлбэрийг баяжуулах, зохиож байгаа ажилдаа бүх нийтийг өргөн хамран оролцуулах явдал юм.

Иймд МЗНН—ийн бүх салбар зөвлөлүүдийн ажлыг үндсээр нь эрс сайжруулах явдал чухлаар шаардагдаж байна.

Ялангуяа Зөвлөлт Холбоот Улсаас уригдан ирсэн мэргэжилтнүүдийг дагалдан сургах ажлыг МЗНН—ийн байгууллагууд шууд хяналтандаа авч дэргэдэх нам, олон нийтийн байгууллагуудтайгаа хамтран ямар мэргэжилтнийг, хэн хэнийг дагалдуулан яаж сургах, хэдий хугацаанд ямар мэргэжил эзэмших талаар нь нарийн тооцоолж сурган ажиллах явдал чухал байна.

Салбар зөвлөлүүдийн ажлыг аймгийн зөвлөл бусад байгууллагуудтай хамтран шалгах, удирдах арга барилыг эрс сайжруулж нийгэмлэгээс олон түмний дунд зохиож байгаа ажлаараа тэргүүний амжилтанд хүрсэн салбар зөвлөлүүдийн ажлын туршлагыг судлан нийтэд дэлгэрүүлэх, салбар зөвлөлүүдийг, гарын авлага гэгээрлийн ажлын материалаар байнга хангаж байх арга хэмжээнүүдийг авч ажиллах хэрэгтэй. МЗНН—ийн байгууллагаас гишүүд олон түмний дунд зохиох зохион байгуулалт, үзэл суртлын ажлыг аж ахуй, зохион байгуулалтын ажилтай нягт холбон ажиллах явдал МЗНН—ийн аймгийн зөвлөл, бүх зөвлөл, салбаруудын өмнө чухал зорилт болон тавигдаж байна. ***Б.Дорж***

*



Баян сумын бага сургуулийн 3 дугаар ангийн сурагч Цэрэндоржийн Есөнжин энэ он гарсаар 65 ном уншжээ.

*Гэрэл зургийг Г.Шагдарсүрэн*

# Уринш боловсруулалтыг чанартай хийе

Уринш боловсруулалтыг хавар эрт тариалангийн ажил дуусмагц эхэлж 6 дугаар сарын эхний 15 хоногт багтаан дуусгах нь ашигтай.

Уринш боловсруулалт тариалангийн талбайг хог ургамал, хорлогчдоос цэвэрлэж хөрсийг ус чийг, шим тэжээлийн бодисоор хангах үндсэн агуулгатай.

Уринш хагалалт газар орны хөрс, цаг уурын байдал, шимт тэжээлийн бодисын их багаас болж газар бүр харилцан адилгүй агротехник шаардана.

Жишээ нь: Зарим газар хур тундас элбэгтэй, шим тэжээл сайтай, хар шороон хөрстэй байхад, зарим газар хур тундасгүй сийрэг, хагалах гүн нь нимгэн, шим тэжээл муутай элсэнцэр буюу хужирлаг хөрс тохиолддог.

Иймээс уринш хагалах газрыг сонгож авахдаа боловсруулах агротехникийг урьдаас төлөвлөж зөв хийх шаардлагатай.

Манайд уринш хагалалт голцуу 20—22 см-ийн гүнд туслах хутгатай хөрс хөмрүүлэгчтэй анжисаар хийгдэж байгаа боловч хөрсний байдал тариалах ургамлын төрлөөс болж хагалах гүн өөрчлөгдөж болно. Уринш дотроо олон янз боловч манайд хамгийн өргөн хэрэглэгдэж байгаа нь эртний уринш юм.

Эртний уриншийг хавар эрт хаврын тариалангийн үеэр буюу дөнгөж дуусмагц эхэлж 6 дугаар сарын 15—ны дотор дуусгаад, өнгөн сийрүүлэлт хийх зэргээр зэрлэг ургамал устгаж өвөл нь цас тогтоож, хавар эрт борнойдож тариалана.

Эртний уриншийг туслах хутгатай хөрс хөмрүүлэгчтэй 4—3 хушуутай анжисаар гол төлөв 20—22 см—ийн гүн хагалдаг.

Хэрэв уринш хагалагдаж байгаа талбай хэтэрхий нягтарсан хатуу буюу зэрлэг ургамлын хүчирхэг үндэстэй бол хагалахын өмнө эндэчлүүрээр 10—12 см-ийн гүнд явуулж, хэд хоноод зэрлэг ургамал бүрэн соёолж гүйцэхийн хамт хөрс эргүүлэгчтэй анжисаар 25—27 см—ийн гүн хагалж зэрлэгийг устгана.

Хэтэрхий нягтарсан ширэнг хөрстэй атар газрыг 3—4 хушуутай анжисаар хагалахад трактор хүч алдахгүй хялбар байдаг.

Түүнчлэн тракторoор удаан явж хагалахад хөрс эргэхдээ муу байдаг учир хөрс хагалахдаа аль болохоор хурдан явбал хөрс сайн эргэж, сайн боловсрогдоно.

Харин газрын гологдол гаргаж болохгүй.

Манай сангийн аж ахуй, хөдөө аж ахуйн нэгдлүүдэд 1959 оны газар зохион байгуулалтын судалгаагаар атар газар 63 мянга 707 га, 1962 оны судалгаагаар 209444 га атар газартай юм.

Энэ газрыг зөв зохион байгуулалттай ашиглана гэдэг бол хөдөө аж ахуйн бүх салбарыг хөгжүүлэх чухал нөхцөл болно.

Иймээс нэг га газрыг ч гэсэн зөв дүүрэн ашиглах хэрэгтэй.

Харин өөрийн дураар улсын экспидицийн судалгаа хийгдээгүй газрыг хагалах явдлыг зогсоож энэ жилээс улсын экспидицийн судалгаа хийгдсэн газрыг зөв тооцоолон хагалан боловсруулж газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь чухал байна.

Шинээр уриншилж боловсруулах газрыг урьдаас зөв сонгон олж талбайнуудыг зөв зохион байгуулах нь уринш боловсруулах мөн цаашид боловсруулж үр суулгах, хураахад тохиромжтой нөхцлийг бүрэлдүүлдэг.

Газар тариаланд ээлжлэн тариалах систем нэвтрүүлэх зорилт тавьж байгаа энэ үед тариалангийн талбай 200—400 га, загоны урт 1500—2000 метр барих нь тохиромжтой байна.

Хагалах талбайг сонгож авсаны дараа талбайнуудаа аль болохоор дөрвөлжлөн зохион байгуулж эгнээ хоорондуур нь авто машин, хөсөг, трактор, чиргүүл машинуудын явахад тохиромжтой зам гаргаж хагалах нь чухал.

Талбайг хагалахын өмнө талбайн хоёр талд трактор анжис борнойтойгоо эргэх зурвас гаргах хэрэгтэй. Эргэх зурвасны өргөн ДТ—54 тракторoор 3—5, хушуутай анжисаар хагалахад 16—22 м, С—80 тракторoор 5—12 м, хушуутай анжисаар хагалахад 22—28 м, белорус тракторoор хагалахад 8—18 метр байна.

Талбайг хагалж тарьсаны дараа эргэх зурвасыг уртааш нь явж хагалана.

Хагалах загоныг маш шулуун татах шаардлагатай байдаг.

Загоныг цэх шулуун татахгүй бол загоны гол захад нь хагалахгүй зууван газар үлдэж түүнийг дахин хагалахад хүрдэг бөгөөд ингэснээр урьд хагалагдсан газар дахин хагалагдаж гуу шуудуу, далан үлдэж гологдол гардаг. Нөгөө талаар загон муруй татсанаас болж олон дахин эргэж хүн явалт ихсэх, шатахуун их зарцуулах болно Н.***Мишиг***